



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭЭДЭЭ

№129 /343/

2022.07.26

Цаг үе, үйл явдал

“СОЁМБО РЕДАКЦ”-ЫН ХАМТ ОЛОН САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДЭВ



ЗХЖШ-ын Ажиллагааны Удирдлагын газрын орлогч дарга хурандаа Ц.Батсайханы гэр бүл бол Зэвсэгт хүчинтэй ажил, амьдралаа холбосон үлгэр жишээ гэр бүл юм. Хэлж ирдэггүй амьдралын саад бэрхшээлд тэд шантарч цөхрөлгүй тэмцэж хань Д.Өнөрцэцэгийг гадаад оронд өндөр өртөгтэй хагалгаанд оруулах шаардлагатай болсон. "Цэргийн гэр бүлээ дэмжье" хандивын аянд нэгдэж, халуун сэтгэлийн гараа сунган дэмжлэг үзүүлсэн ЗХЖШ-ын даргын зөвлөл, Ажиллагааны удирдлагын газар, Бодлого, стратегийн газар, Захиргаа удирдлагын хэлтэс, Сургалтын бодлогын газар, Санхүүгийн хэлтэс, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга, инженерийн цэргийн удирдах газар, Цэргийн албаны хэлтсийн хамт олон болон Зэвсэгт хүчний 013, 032, 124, 142,

150, 186, 189, 256, 340, 342 дугаар ангидын удирдлага, хамт олонд гэр бүлийнхээ зүгээс талархал илэрхийлж байгаагаа биднээр дамжуулан уламжилсан юм. Хэдийгээр олон анги, байгууллага, сайхан сэтгэлт хүмүүс дэмжиж тусалж байгаа ч эмчилгээний зардал өндөр, хугацаа давчуу, өвчин зовлонтой цаг өрсөн тэмцэлдэж байгаа энэ хүнд цаг үед нь "Соёмбо" редакцын хамт олны зүгээс "Цэргийн гэр бүлээ дэмжье" хандивын аянд нэгдэж, эх орныхоо төлөө зүтгэж буй нэгэн сайхан гэр бүлийг аз жаргалтай амьдрах итгэлийн гал, сэтгэлийн дэм хайрлахыг уриалж байна. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!
Хандивын данс: Хаан банк 500 780 75 78 Д.Өнөрцэцэг. Утас: 99060601, 99710111

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.173.00	3.180.0
EUR 🇪🇺	3.250.0	3.270.0
CNY 🇨🇳	471.00	474.00
RUB 🇷🇺	51.50	52.80
JPY 🇯🇵	22.90	23.18
KRW 🇰🇷	2.38	2.41

ЗУРХАЙ



"НӨХӨРСӨГ БУУХИА" ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАВ



цэг бүрд 1 гишүүн байрлана. Эхний цэгээс эхлэн тухайн даалгаврыг бүрэн, зөв хийж гүйцэтгэсний дараа дараагийн цэг рүү гүйж тухайн цэгийн гишүүний гарыг цохисноор даалгаврыг гүйцэтгэж эхэлнэ. Энэ журмаар гарааны цэгээс сүүлийн цэг хүртэл даалгаврыг хийж гүйцэтгэн барианд хүрсэн нийт хугацаагаар буюу хамгийн богино хугацаанд хийж дууссанаар байрыг шалгаруулав.

Байр эзэлсэн цэргийн алба хаагчдад Сургалтын төвийн захирал Хурандаа С.Жавхлансүрэн өргөмжлөл, медалийг гардуулан өглөө.

Мөн энэ үеэр ҮБХИС-ийн Харуул үйлчилгээний ротын хугацаат цэргийн алба хаагчид Оюутан цэргийн өдөр тутмын цагийн хуваарьт үйл ажиллагаа, хичээл сургууль, сургалтын хуваарьтай танилцсан юм.

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.21-20.37

БАРИЛДЛАГА:

Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Нэр өнгө

Суудал: Ус

Энэ өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лус тахих, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

"Оюутан цэрэг-2022" сургалтад хамрагдаж байгаа оюутан залуус ҮБХИС-ийн Харуул үйлчилгээний ротын хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Нөхөрсөг буухиа" тэмцээн энэ сарын 24-ний өдөр Шар хад хээрийн сургалтын төвд амжилттай зохиогдож шилдгүүд тодорлоо. ҮБХИС-ийн Харуул үйлчилгээний ротын 18 цэргийн алба хаагч, "Оюутан Цэрэг 2022"-ын 30 оюутан 8 багт хуваагдан орноос босож, хурааж гар дээр 30 суниах, автоматын хагас задаргаа, эвлүүлгээ, химийн норматив гүйцэтгэх, тэмээн шатаар явах, дүүжинд 3 суниаж, татаж давах, 20 удаа туухай өргөх гэсэн 6 цэгт өгөгдсөн үүргүүдийг гүйцэтгэснээс тэргүүн байранд ҮБХИС-ийн ахмад Г.Цолмонхүү захирагчтай Харуул үйлчилгээний ротын түрүүч Б.Хосбаяр ахлагчтай 3 дугаар баг, дэд байранд Оюутан цэрэг Сургалтын төвийн ахмад А.Очпүрэв II ротын баг, гутгаар байранд Оюутан цэрэг Сургалтын төвийн дэслэгч А.Амарсайхан захирагчтай I ротын баг тус тус шалгарлаа.

Хурд, хүч, авхаалж самбаагаа дайчлан уралдсан дээрх тэмцээн нь баг тус бүр 6 гишүүнтэй бөгөөд



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 575,727,384

Эдгэрсэн

Нийт: 545,801,770

Нас барсан

Нийт: 6,404,676

Цахим шууданд

“АРВАЙХЭЭР” ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙХЭН ЁСЛОЛЫН ЖАГСААЛААР АЛХЛАА

Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Өвөрхангай аймаг үүсэн байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяр 7 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Түүхт ойгоор “Арвайхээр цэргийн хүрээ”-ийнхэн оройн тооллого зохион байгуулж, наадмын төв талбайд цэргийн ёслолын жагсаалаар алхлаа.

Цэргийн ёслолын жагсаалд төрийн цэргийн болон хууль сахиулах 6 байгууллагын 600 гаруй алба хаагч оролцсон бөгөөд жагсаалыг Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Д.Сүхбат командлан алхсан юм.

Орон нутгийн түүхт ойн баяр наадмын нээлт, хаалт болон арын албанд хүн хүчний дэмжлэг үзүүлэх, хурдан морины уралдаан зохион байгуулахад Зэвсэгт хүчний 256 дугаар ангийнхан тэргүүлэх үүрэгтэй ажиллаж байна.

Ахлах дэслэгч Т.АЛТАНТУУЛ



ХООЛЛОНГОО МЭДЛЭГЭЭ ТЭЛЬЕ

АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Цэргийн гал тогооны ширээнд хууль тогтоомж, цэргийн дүрэм, Монгол Улсын баатар, Жанжид, олны танилын хүмүүсийн хэлсэн үг, үндэсний бичгээр бичсэн онч мэргэн үгсийг агуулсан зурагт хуудас байршуулав.

Ингэснээр зэвсэгт хүчний 338 дугаар ангийн ХЦАХ-чид болон бие бүрэлдэхүүний цэргийн дүрэм, хуулийн мэдлэгээ дээшлүүлэхэд ихээхэн тус нэмэр болж байгаа юм.

Бууг "Хөлд",
"Мөрөнд", "Оосорт"
болон "Цэвжинд"
байдалд авч явахад
зүүн гарыг харин бууг
"Нуруунд" авч явахад
хоёр гарыг хаялж
алхана



ҮБХИС-ИЙН АЛБА ХААГЧ НАР ХҮССЭН СУРГУУЛЬДАА ТЭНЦЭВ

ҮБХИС-ийн 029-рангийн хугацаат цэргийн алба хаагчид цэргийн албыг хаангаа их, дээд сургуульдаа цахимаар суралцаж, элсэлтийн Ерөнхий шалгалтад өөрийгөө бэлтгэж, хүссэн их, дээд сургуульдаа элсэх боломж байдгийг цөөнгүй түрүүч, байлдагч нар үлгэрлэн харуулсаар байна.

Үүний нэг нь Зэвсэгт хүчний 029 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч, дэд түрүүч С.Бат-эрдэнэ нь ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуульд, байлдагч Н.Мөнгөнбаатар, Э.Бат-эрдэнэ ҮБХИС-ийн Батлан хамгаалах Мэргэжил сургалт үйлдвэрийн төвд элсэлээ.

Мөн байлдагч А.Итгэлт, Б.Эрхэм-билэг нар нь элсэлтийн Ерөнхий шалгалт болон эрүүл мэндийн үзлэг,

ур чадвараараа их дээд сургуульд тэнцэж, хүссэн мэргэжлээрээ суралцах боломжтой болжээ.



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Монгол Улсын ЗХЖШ-ын Агаарын цэргийн командлагч шинээр томилогдсонтой холбогдуулан тус албан тушаалд томилогдсон хурандаа Т.Ганбат, АЦК-ийн материал техникийн хэлтсийн дарга хурандаа Г.Хаччулуун нар Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн үйл ажиллагаатай

танилцан бие бүрэлдэхүүнд үүрэг даалгавар өгөв. Тодруулбал, Зенит пуужингийн цогцолборын хэвийн ажиллагааг хангаж ашиглалтад оруулах бүх талын бололцоог хангах, инженер техникийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах болон албанд хандах хандлагаа дээшлүүлж тэргүүний ангийн болзлыг

хангах хэмжээнд хурч ажиллах зэрэг үүргийг өглөө. Эцэст нь нь тэрээр бие бүрэлдэхүүнийг аливаа осол зөрчлөөс урьдчилан сэргийлж, сахилга хариуцлагатай ажиллахыг үүрэг болголоо.

Мөн эл өдөр Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн бие бүрэлдэхүүн Монгол Улсын цэргийн тангараг давтах ажиллагааг зохион байгууллаа.



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Sojombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)